

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Төрийн аудитын санал, дүгнэлт	3
Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	14
3.4. Материаллаг байдал.....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.9. Аудитын илрүүлэлт	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж.....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16
4. Менежментийн захидал	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ
ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ II, III
ШАТНЫ ТӨСЛИЙН ЗАХИРАЛ
Ч.БАТСАНСАР ТАНАА

2021.02.25 № 07/489
танай _____-ны № _____-т

Аудитын санал, дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох I шатны төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох I шатны төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн, үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг, хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 51.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу, үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	349,292,053.34
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	335,870,452.34
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	335,870,452.34
3122	Гадаад валют	0.00	335,870,452.34
31223	Арилжааны банк дахь харилцах	0.00	335,870,452.34
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	13,421,601.00
354	Хангамжийн материал	0.00	13,421,601.00
35410	Бичиг хэргийн материал	0.00	2,014,250.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	2,515,000.00
35470	Бусад Хангамжийн материал	0.00	8,892,351.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,606,073.83	1,971,415.19
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,606,073.83	1,971,415.19
392	Биет хөрөнгө	340,595.00	305,700.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	347,985.00	347,985.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,390.00)	(42,284.44)
393	Биет бус хөрөнгө	2,265,478.83	1,665,714.63
39301	Програм хангамж	2,392,500.00	2,392,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(127,021.17)	(726,785.37)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,606,073.83	351,263,468.53
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,606,073.83	351,263,468.53
51	Засгийн газрын хувь оролцоо	2,606,073.83	351,263,468.53
512	Хуримтлагдсан үр дүн	2,606,073.83	351,263,468.53
51210	Өмнөх үеийн үр дүн	0.00	2,606,073.83
51220	Тайлант үеийн үр дүн	2,606,073.83	348,657,394.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,606,073.83	351,263,468.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	52,323,900.00	2,874,239,360.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	2,257,298,860.50
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	120,00.00
120009	Бусад орлого	0.00	120,000.00
122	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	0.00	2,257,178,860.50
122002	Хандив-Гадаад	0.00	2,257,178,860.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	52,323,900.00	616,940,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	52,323,900.00	616,940,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	52,323,900.00	616,940,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	49,717,826.17	2,547,636,327.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	49,717,826.17	2,547,636,327.27
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	49,717,826.17	2,477,402,058.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	0.00	267,989,654.76
210101	Үндсэн цалин	0.00	267,989,654.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,483,837.00	43,142,673.89
210201	Тэтгэврийн даатгал	3,729,037.00	29,354,183.05
210202	Тэтгэмжийн даатгал	438,700.00	3,453,422.71
210203	ҮОМШ өвчний даатгал	351,000.00	2,756,018.17
210204	Ажилгүйдлын даатгал	87,700.00	689,004.54
210205	Эрүүл мэндийн даатгал	877,400.00	6,890,045.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	71,293,714.50
210301	Гэрэл цахилгаан	0.00	1,212,487.96
210302	Түлш, халаалт	0.00	1,404,841.57
210304	Байрны түрээс	0.00	68,676,384.97
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	24,439,292.24
210401	Бичиг хэрэг	0.00	6,946,278.00
210402	Тээвэр шатахуун	0.00	2,605,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	0.00	5,130,203.24
210404	Ном хэвлэл	0.00	131,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	9,626,611.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	14,437,350.00
210702	Дотоод албан томилолт	0.00	14,437,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,870,696.00	2,052,043,324.88
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,870,696.00	2,049,843,126.58
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	2,178,198.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,411.17	4,056,048.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	3,421,390.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	134,411.17	634,658.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	228,882.00	70,234,268.36
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	228,882.00	70,234,268.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	228,882.00	70,234,268.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	2,606,073.83	326,603,033.23
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	28,461,010.12
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0.00	28,461,010.12
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	6,406,648.65
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	0.00	6,406,648.65
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	0.00	22,054,361.47
5	НИЙТ ҮР ДҮН	2,606,073.83	348,657,394.70

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	52,323,900.00	944,215,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	327,275,000.00
122	Тусламжийн орлого	0.00	327,275,000.00
122002	Хандив тусламж-гадаад	0.00	327,275,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	52,323,900.00	616,940,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	52,323,900.00	616,940,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	52,323,900.00	616,940,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	52,323,900.00	957,674,409.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	52,323,900.00	957,674,409.13
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	52,095,018.00	560,165,140.77
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	0.00	267,989,654.75
210101	Үндсэн цалин	0.00	267,989,654.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,483,837.00	43,142,673.90
210201	Тэтгэврийн даатгал	3,729,037.00	29,354,093.06
210202	Тэтгэмжийн даатгал	438,700.00	3,453,422.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	351,00.00	2,756,018.17
210204	Ажилгүйдлийн даатгал	87,700.00	689,004.54
210205	Эрүүл мэндийн даатгал	877,400.00	6,890,135.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	71,293,714.50
210301	Гэрэл, цахилгаан	0.00	1,212,487.96
210302	Түлш, халаалт	0.00	1,404,841.57
210304	Байрны түрээс	0.00	68,676,384.97
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	17,301,393.24
210401	Бичиг хэрэг	0.00	4,832,700.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	5,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	5,130,203.24
210404	Ном хэвлэл	0.00	131,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	2,207,290.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,740,485.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,392,500.00	0.00
210602	Тавилга	347,985.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	14,437,350.00
210702	Дотоод албан томилолт	0.00	14,437,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,870,696.00	122,271,464.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,870,696.00	120,071,266.08
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	2,178,198.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	23,728,890.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	23,728,890.00
212	ТАТААС	0.00	327,275,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	228,882.00	70,234,268.36
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	228,882.00	70,234,268.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	228,882.00	70,234,268.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	(13,458,909.13)
14	Бусад эх үүсвэр	0.00	28,461,010.12
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0.00	28,461,010.12
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	28,461,010.12
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	0.00	6,406,648.65
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	15,002,100.99
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	335,870,452.34

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,606,073.83	2,606,073.83
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн бууралт	0.00	0.00	0.00	0.00
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,606,073.83	2,606,073.83
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,606,073.83	2,606,073.83
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	348,657,394.70	348,657,394.70
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн бууралт	0.00	0.00	0.00	0.00
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	351,263,468.53	351,263,468.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,459,638,500.00	4,747,247,861.77	(287,609,361.77)	106.45
УРСГАЛ ЗАРДАЛ	2,538,289,500.00	2,490,069,001.27	48,220,498.73	98.10
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,538,289,500.00	2,490,069,001.27	48,220,498.73	98.10
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	305,011,500.00	267,989,654.75	37,021,845.25	87.86
Үндсэн цалин	305,011,500.00	267,989,654.75	37,021,845.25	87.86
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,566,500.00	43,142,673.90	9,423,826.10	82.07
Тэтгэврийн даатгал	36,988,500.00	29,354,093.06	7,634,406.94	79.36
Тэтгэмжийн даатгал	3,893,400.00	3,453,422.71	439,977.29	88.70
ҮОМШӨ-ний даатгал	3,116,100.00	2,756,018.17	360,081.83	88.44
Ажилгүйдлийн даатгал	779,500.00	689,004.54	90,495.46	88.39
Эрүүл мэндийн даатгал	7,789,000.00	6,890,135.42	898,864.58	88.46
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,053,000.00	71,293,714.50	4,759,285.50	93.74
Гэрэл, цахилгаан	1,971,600.00	1,212,487.96	759,112.04	61.50
Түлш, халаалт	2,587,100.00	1,404,841.57	1,182,258.43	54.30
Байрны түрээс	71,494,300.00	68,676,384.97	2,817,915.03	96.06
Хангамж, бараа материалын зардал	20,262,800.00	17,301,393.24	2,961,406.76	85.39
Бичиг хэрэг	4,868,000.00	4,832,700.00	35,300.00	99.27
Тээвэр, шатахуун	5,000,000.00	5,000,000.00	0.00	100
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,866,800.00	5,130,203.24	736,596.76	87.44
Ном, хэвлэл	263,000.00	131,200.00	131,800.00	49.89
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,265,000.00	2,207,290.00	2,057,710.00	51.75
Томилолт, зочны зардал	25,000,000.00	14,437,350.00	10,562,650.00	57.75
Дотоод албан томилолт	25,000,000.00	14,437,350.00	10,562,650.00	57.75
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,033,445,700.00	2,052,175,324.88	(18,729,624.88)	100.92
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,033,040,700.00	2,049,975,126.58	(19,934,426.58)	100.98
Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000.00	22,000.00	8,000.00	73.33
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,375,000.00	2,178,198.30	1,196,801.70	64.54
Бараа үйлчилгээний бусад зардал	25,950,000.00	23,723,890.00	2,221,110.00	91.44
Бараа үйлчилгээний бусад зардал	25,950,000.00	23,723,890.00	2,221,110.00	91.44
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,538,289,500.00	2,874,119,360.50	(335,829,860.50)	117.48
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	616,940,500.00	616,940,500.00	0.00	100
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	616,940,500.00	616,940,500.00	0.00	100
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	1,921,349,000.00	2,257,178,860.50	(335,829,860.50)	117.48
Хандив тусламж /гадаад/	1,921,349,000.00	2,257,178,860.50	(335,829,860.50)	117.48

ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
АЖИЛЛАГСАДЫН ТОО	14	12	2	85.7
Удирдах ажилтан	1	1	0	100
Гүйцэтгэх ажилтан	13	11	2	84.6
Үйлчлэх ажилтан	0	0	0	0.0
Гэрээт ажилтан	0	0	0	0.0

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шатны төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төслийн захирал Ч.Батсансар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн бодлогын үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, худалдан авах ажиллагааны цахим системийн талаарх өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 12 дугаар сарын 21-нээс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын захиалгаар Интер аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр, ахлах аудитор С.Уртнасан, аудитор Б.Гомбо нар хариуцаж хэрэгжүүлэв.

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шатны төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 155/2021 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шатны төсөл нь 2020 оны үйл ажиллагааг үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлж, үр ашигтайгаар төлөвлөх, төслийн хүрээнд хийгдэх худалдан авах ажиллагаанд ил тод өрсөлдөх тэгш эрхийн боломжийг хангах, төлөвлөгөөний хэрэгжилт, төслийн тогтвортой байдлыг ханган ажиллах зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант онд техникийн зөвлөх компанитай зөвлөх үйлчилгээний гэрээг 2020 оны 3 дугаар сарын 2-нд үзэглэснээр төслийн II, III шатны үйл ажиллагааг албан ёсоор эхлүүлсэнд тооцож байна. Төслийн II, III шатны үйл ажиллагаанд 27.5 сая еврогийн буцалтгүй тусламжийн санхүүжилтийг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газраас олгохоор тохирсон байна.

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын болон Сангийн сайдын 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог батлах тухай” 115/A/405 дугаар тушаалаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог шинээр батлуулсан байна.

2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 33 ажил төлөвлөсөн бөгөөд ажлын гүйцэтгэл 51.3 хувь байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Германы Сэргээн Босголтын Зээлийн Банк (KfW)-ны худалдан авах ажиллагааны тухай “Түншлэгч Улсуудтай хийх санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд зөвлөх үйлчилгээ, ажил, үйлдвэрийн байгууламж, барааны болон зөвлөх бус үйлчилгээ худалдан авах ажиллагааны удирдамж” 2019 онд шинэчлэгдэн 2020 оноос хэрэгжиж эхэлсэн.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шатны төслийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

2020 онд Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шатны төслийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

2020 оны шилэн дансанд шалгалт хийгээгүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,547,636.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 50,952.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шатны төслийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 348,657.4 мянган төгрөгөөр буюу 134.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	349,292.0	349,292.0
Бараа материал	0.00	13,421.6	13,421.6
Үндсэн хөрөнгө	2,606.1	1,971.4	(634.7)
Нийт хөрөнгө	2,606.1	351,263.5	348,657.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,606.1	351,263.5	348,657.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,606.1	351,263.5	348,657.4

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 349,292.0 мянган төгрөг байна. Төслийн үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдөр эхэлж эхний санхүүжилтүүдийг авсан бөгөөд тус хандив тусламжийн санхүүжилтийг бүрэн зарцуулаагүйтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 351,263.5 мянган төгрөг болж 348,657.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үед худалдан авах ажиллагааны санхүүжилтийг авч II, III шатны төслийн худалдан авах ажиллагааны гүйцэтгэл 53.3 хувьтай хэрэгжиж тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шатны төслийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,821,915.5 мянган төгрөгөөр, нийт зардал 2,497,918.5 мянган төгрөгөөр өссөн байна. Уг төслийн техникийн зөвлөх компаниудтай зөвлөх үйлчилгээний гэрээг 2020 оны 3 дугаар сарын 2-нд үзэглэснээр төслийн II, III шатны үйл ажиллагааг албан ёсоор эхлүүлсэнд тооцож зөвлөхийн төлбөр хийгдсэнтэй холбоотой юм.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,538,289.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн 19 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,538,289.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 616,940.5 мянган төгрөгийг улсын төсвөөс 1,921,349.0 мянган төгрөгийг гадаад хандив тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 616,940.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, гадаад хандив тусламжаас 327,275.0 мянган төгрөг, нийт 944,215.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 957,674.4 мянган төгрөгийг зарцуулж 70,234.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,490,069.0 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал 37,021.8 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 9,423.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4,759.3 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 2,961.4 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардал 10,562.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 2,221.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

2020 оны “Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” ангиллын нийт зарцуулалтын дүн 2,049,843.1 мянган төгрөг байна. Зардлын задаргааг дараах хүснэгтээр харуулав.

/Мянган төгрөгөөр/

№	Хийгдсэн ажил	Санхүүжилтийн эх үүсвэр	
		Гадаад тусламж	Монгол улсын засгийн газар
1	Улсын төсвийн санхүүжилтээр хийгдсэн төлбөр тооцоо (цалин хөлс, тээврийн хэрэгслийн даатгал, баннер хэвлүүлэх, зарын талбөр, компьютерын засвар гэх мэт)	-	106,480.3
2	Зөвлөхийн төлбөр (Шууд Германаас төлөгдсөн)	452,166.0	
3	Зөвлөхийн төлбөр (Шууд Германаас төлөгдсөн)	1,477,737.9	
4	Төслийн бодлого үйл ажиллагааг талуудад танилцуулах хурал семинарын хоол, хурлын танхимын түрээс, цайны завсарлагын зардал	3,900.0	
5	Төслийн бодлого үйл ажиллагааг талуудад танилцуулах хурал семинарын бичиг хэргийн зардал төлбөр	124.0	

4	Санхүүгийн гарын авлага боловсруулах зөвлөх үйлчилгээний төлбөр	9,420.0	
5	Дамжуулагч банкны шимтгэл (төслийн дансанд санхүүжилт татахад)	4.9	
6	Интернэт банкны хураамж	10.0	
	Дүн	1,943,362.8	106,480.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс хугацаандаа оруулсан 113 мэдээлэл, хугацаа хоцроосон 34 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 23.1 хувьтай байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/Мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	0.0	1	0.0	0	0.0	23.1

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл “Шилэн дансны зарчим”-г мөрдөж ажиллах талаар албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын зөвлөмж

Аудитаар Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шатны төслийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар өмнөх аудитын өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь УСНББОУС-д нийцүүлж, мөн өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй байна.

1.2. Эрсдэл:

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн санхүүгийн тайлагналын үнэн зөв толилуулга алдагдах, санхүүгийн тайлан хэрэглэгчдэд шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг өгч чадахгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

“Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 18 дугаар зүйл: Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалтын 18.2 дугаар хэсэгт заасан “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын өгсөн зөвлөмжийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу биелүүлж ажиллана.

2. Худалдан авах ажиллагааны цахим системтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1-д Дараах этгээд захиалагч байна, 4.1.3-д Өрийн удирдлагын тухай хуулийн 4.121-д заасан төсөл хэрэгжүүлэгч гэж заасны дагуу тус төслийн нэгж нь уг хуулийн 21 дүгээр зүйл Тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлэх, 21.1-д Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ гэж заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим системд байршуулах үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Мөн худалдан авах ажиллагааны гүйцэтгэл 53.3 хувьтай байгааг хангалтгүй гэж үзэж байна.

2.2. Эрсдэл:

Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчим алдагдаж байна. Мөн худалдан авах ажиллагааны гүйцэтгэл хангалтгүй байгаа нь уг төсөл хаагдах хүртэлх хугацаанд төлөвлөсөн санхүүжилтыг бүрэн, үр ашигтай зарцуулж чадахгүйд хүрнэ.

2.3. Өгсөн зөвлөмж:

Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах мөн худалдан авах ажиллагааны гүйцэтгэлд анхаарч ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан толилуулах ёстой 147 мэдээллээс 34 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4

дүгээр зүйлийн 4.1.3-т “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2. Эрсдэл:

Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтаны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”

3.3. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл “Шилэн дансны зарчим”-г мөрдөж ажиллах, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд цаг хугацаанд нь толилуулж байх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын өгсөн зөвлөмжийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу биелүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.02.23			САГ-2021/18/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шатны төсөл		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь УСНББОУС-д нийцүүлж, мөн өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч	Г.Эрдэнэбаясгалан
2	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1-д Дараах этгээд захиалагч байна, 4.1.3-д Өрийн удирдлагын тухай хуулийн 4.121-д заасан төсөл хэрэгжүүлэгч гэж заасны дагуу тус төслийн нэгж нь уг хуулийн 21 дүгээр зүйл Тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлэх, 21.1-д Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ гэж заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим системд байршуулах үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Мөн худалдан авах ажиллагааны биелэлт хангалтгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Худалдан авах ажиллагааны ажилтан	Ц.Амарбаяр, Ц.Оюунбилэг
3	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан толилуулах ёстой 147 мэдээллээс 34 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	-	Албан шаардлага өгөх	Санхүүгийн ажилтан	Э.Замбага



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 30/A0170078

Улаанбаатар хот

САГ-2021/17/СТА-ТХН

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шат” төслийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шат” төслийн 2020 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд байршуулах 147 мэдээллээс 34 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байх бөгөөд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг үнэн зөв, ил тод, хугацаанд нь байршуулж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 05 сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, ажиллахыг “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шат”-ны төслийн санхүүгийн ажилтан Э.Замбагад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АУДИТОР:
ИНТЕР АУДИТ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ:

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ЦЭРЭНХҮҮ
Ч.МӨНХБАЯР

[illegible]

[illegible]

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting or typing. There are no margins, text, or other markings on the page.